

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/12/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775, khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.08.24 № 191

танай _____ -ны № _____ -т

БАЯН-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЭНХБАРС ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011021223

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,291,843.53	169,985,213.53
33	АВЛАГА	5,988,940.00	-
335	Бусад авлага	5,988,940.00	-
3351	Байгууллагаас авах авлага	5,988,940.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	167,302,903.53	169,985,213.53
354	Хангамжийн материал	167,302,903.53	169,985,213.53
35410	Бичиг хэргийн материал	36,373,821.03	40,386,131.03
35420	Аж ахуйн материал	129,329,082.50	129,599,082.50
35440	Түлш, шатах тослох материал	1,600,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,474,179,048.67	4,480,749,080.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,474,179,048.67	4,480,749,080.00
392	Биет хөрөнгө	4,392,300,048.79	4,398,947,080.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,808,094,479.07	4,883,579,250.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	(707,926,091.18)	(824,685,522.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,072,441.00	198,970,137.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(106,801,812.42)	(123,122,367.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,569,033.36	123,975,010.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,848,003.15)	(56,598,067.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,194,895.00	244,527,758.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,717,755.89)	(47,699,116.80)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	113,662,863.00	-
393	Биет бус хөрөнгө	81,878,999.88	81,801,999.84
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(231,000.12)	(308,000.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	81,340,000.00	81,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,647,470,892.20	4,650,734,293.53
4136	Бусад өглөг	5,988,940.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,988,940.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,641,481,952.20	4,650,734,293.53
51	Засгийн газрын хувь оролцоо	4,641,481,952.20	4,650,734,293.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	518,879,854.43	518,879,854.43
51101	Өмч: - төрийн	518,879,854.43	518,879,854.43
512	Хуримтлагдсан үр дүн	3,682,939,086.83	3,692,191,428.16
51210	Өмнөх үеийн үр дүн	3,682,939,086.83	3,682,939,086.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	9,252,341.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	439,663,010.94	439,663,010.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,647,470,892.20	4,650,734,293.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (0)	1,397,165,811.00	1,737,480,605.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,569,948.00	292,330,265.05
120	Нийтлэг татварын бус орлого	52,189,948.00	292,330,265.05
120017	Үнэ төлбөргүй авсан орлого-Үндсэн хөрөнгө		288,538,955.05
120018	Үнэ төлбөргүй авсан орлого-Бараа материал		3,791,310.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,303,595,863.00	1,445,150,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,139,139,000.00	1,381,417,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,139,139,000.00	1,381,417,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,956,863.00	7,453,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,659,000.00	7,453,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,500,000.00	56,278,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,500,000.00	56,278,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,549,485,592.06	1,614,283,700.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,549,485,592.06	1,614,283,700.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,506,512,900.06	1,456,828,993.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	909,764,697.00	1,063,486,720.00
210101	Үндсэн цалин	630,873,175.00	777,344,596.00
210102	Нэмэгдэл	127,172,914.00	193,262,524.00
210104	Урамшуулал	151,718,608.00	92,879,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,721,200.00	133,176,899.28
210201	Тэтгэврийн даатгал	77,330,100.00	91,569,845.14
210202	Тэтгэмжийн даатгал	9,097,800.00	10,757,787.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,278,300.00	8,083,187.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,819,600.00	2,540,601.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,195,400.00	20,225,479.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,910,461.00	41,501,342.00
210301	Гэрэл, цахилгаан	19,476,469.00	10,801,994.00
210302	Түлш, халаалт	33,433,992.00	30,699,348.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,676,530.00	7,650,061.00
210401	Бичиг хэрэг	1,457,450.00	1,525,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,587,823.00	1,995,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,000.00	1,325,000.00
210404	Ном, хэвлэл	581,700.00	558,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	284,567.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,292,557.00	1,961,694.00
2105	Нормативт зардал	42,357,370.00	28,234,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,181,700.00	350,000.00
210502	Хоол, хүнс	39,237,600.00	26,488,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,938,070.00	1,395,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	624,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	624,500.00
2107	Томиллолт, зочны зардал	4,459,000.00	1,200,000.00
210702	Дотоод албан томиллолт	4,459,000.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,197,999.81	845,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,260,000.00	485,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	338,425,642.25	180,109,500.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,103,000.00	1,763,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,661,980.00	8,867,440.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	322,660,662.25	169,478,360.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,972,692.00	157,454,707.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,972,200.00	26,907,386.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,972,200.00	26,747,386.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	492.00	114,843,027.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	492.00	114,843,027.72
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,704,294.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,704,294.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(152,319,781.06)	123,196,904.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	113,944,563.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	281,700.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	113,662,863.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(113,944,563.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(152,319,781.06)	9,252,341.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,304,975,863.00	1,445,150,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,303,595,863.00	1,445,150,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,139,139,000.00	1,381,417,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,139,139,000.00	1,381,417,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,956,863.00	7,453,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,659,000.00	7,453,940.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,500,000.00	56,278,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,500,000.00	56,278,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,231,313,000.00	1,445,150,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,231,313,000.00	1,445,150,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,188,340,308.00	1,287,695,632.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	909,764,697.00	1,063,486,720.00
210101	Үндсэн цалин	630,873,175.00	777,344,596.00
210102	Нэмэгдэл	127,172,914.00	193,262,524.00
210104	Урамшуулал	151,718,608.00	92,879,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,721,200.00	133,176,899.28
210201	Тэтгэврийн даатгал	77,330,100.00	91,569,845.14
210202	Тэтгэмжийн даатгал	9,097,800.00	10,757,787.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,278,300.00	8,083,187.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,819,600.00	2,540,601.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,195,400.00	20,225,479.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,499,511.00	39,901,342.00
210301	Гэрэл, цахилгаан	19,476,469.00	10,801,994.00
210302	Түлш, халаалт	25,023,042.00	29,099,348.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,976,390.00	9,010,061.00
210401	Бичиг хэрэг	1,457,450.00	1,746,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,587,823.00	1,995,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,000.00	1,325,000.00
210404	Ном, хэвлэл	581,700.00	558,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	-	284,567.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,592,417.00	3,100,694.00
2105	Нормативт зардал	47,219,300.00	28,234,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,181,700.00	350,000.00
210502	Хоол, хүнс	39,237,600.00	26,488,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,800,000.00	1,395,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	624,500.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	624,500.00
2107	Томилголт, зочны зардал	4,459,000.00	1,200,000.00
210702	Дотоод албан томилолт	4,459,000.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,520,000.00	845,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,260,000.00	485,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,180,210.00	11,216,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,103,000.00	1,763,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,077,210.00	9,452,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,972,692.00	157,454,707.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,972,200.00	26,907,386.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,972,200.00	26,747,386.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	492.00	114,843,027.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	492.00	114,843,027.72
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,704,294.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,704,294.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,682,939,086.83	0.00	4,641,481,952.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,682,939,086.83	0.00	4,641,481,952.20
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,682,939,086.83	0.00	4,641,481,952.20
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,682,939,086.83	0.00	4,641,481,952.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,682,939,086.83	0.00	4,641,481,952.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,252,341.33	0.00	9,252,341.33
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	518,879,854.43	439,663,010.94	3,692,191,428.16	0.00	4,650,734,293.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,437,696,400.00	1,307,149,078.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,437,696,400.00	1,307,149,078.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,406,983,900.00	1,280,241,692.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,110,720,400.00	1,063,486,720.00
210101	Үндсэн цалин	782,036,400.00	777,344,596.00
210102	Нэмэгдэл	222,884,000.00	193,262,524.00
210104	Урамшуулал	105,800,000.00	92,879,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,840,100.00	133,176,899.28
210201	Тэтгэврийн даатгал	94,411,300.00	91,569,845.14
210202	Тэтгэмжийн даатгал	8,885,800.00	10,757,787.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,221,400.00	8,083,187.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,107,200.00	2,540,601.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,214,400.00	20,225,479.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,278,800.00	39,901,342.00
210301	Гэрэл, сахилгаан	18,200,000.00	10,801,994.00
210302	Түлш, халаалт	35,578,800.00	29,099,348.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,532,700.00	9,010,061.00
210401	Бичиг хэрэг	1,858,300.00	1,746,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,091,300.00	1,995,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,325,000.00	1,325,000.00
210404	Ном, хэвлэл	558,300.00	558,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	284,567.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,699,800.00	3,100,694.00
2105	Нормативт зардал	78,951,900.00	28,234,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,918,700.00	350,000.00
210502	Хоол, хүнс	73,637,400.00	26,488,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,395,800.00	1,395,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	624,500.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	624,500.00
2107	Томилот, зочны зардал	1,620,000.00	1,200,000.00
210702	Дотоод албан томилот	1,620,000.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	907,800.00	845,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	547,800.00	485,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,132,200.00	3,762,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	418,700.00	298,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,713,500.00	3,463,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,712,500.00	26,907,386.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,712,500.00	26,907,386.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,402,500.00	26,747,386.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	310,000.00	160,000.00
1310	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,437,696,400.00	1,307,149,078.28
131007	ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,437,696,400.00	1,307,149,078.28
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,392,196,400.00	1,277,353,372.28
131008	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,500,000.00	29,795,706.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	7,453,940.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	7,453,940.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	7,453,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7,453,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,465,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,988,940.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	7,453,940.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	7,453,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,453,940.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Энхбарс танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн хамт олны багш , ажилчид, сурагчид, эцэг, эх , асран хамгаалагчид хамтын ажиллагааг өргөжүүлэх, суралцагчийн хөгжил төлөвшилд ахиц гаргах
- Эх хэл, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх
- Сургуулийн хамт олны хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах
- Багш ажлын байран дээрээ мэргэжил, арга зүйгээ тасралтгүй дээшлүүлэх
- Сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Хүүхэд бүрийн оюун ухаан, авьяас чадварыг нээн хөгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,614,283.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 32,285.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,263.4 мянган төгрөгөөр буюу 0.07 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	5,988.9	0	-5,988.9
Урьдчилгаа			
Бараа материал	167,302.9	169,985.2	2,682.3
Үндсэн хөрөнгө	4,474,179.1	4,480,749.1	6,570.0
Нийт хөрөнгө	4,647,470.9	4,650,734.3	3,263.4
Өр төлбөр	5,988.9		-5,988.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,641,482.0	4,650,734.3	9,252.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,647,470.9	4,650,734.3	3,263.4

Авлага, өглөгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материал данс 169,985.2 мянган төгрөг болж 2,682.3 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан аж ахуйн материалаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 4,480,749.1 мянган төгрөг болж 6,570.0 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар 274,186.4 мянган төгрөг, төсвөөр худалдан авсан 1,454.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 16,531.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 113,662,9 мянган төгрөг, акталсан 12,050.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо данс 4,650,734.3 мянган төгрөг болж 9,252.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан.

Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 340,314.7 мянган төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 64,798.1 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материалын үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,584,865.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,584,865.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 147,169.3 мянган төгрөгөөр бууруулж 1,437,696.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,437,696.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,392,196.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 45,500.0 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,392.196.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 45,500.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,437,696.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,307,149.0 мянган төгрөгийг зарцуулж 130,547.3 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,307,149.0 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 47,233.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 5,663.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,469.3 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 14,376.9 мянган төгрөгөөр, үдийн цай болон хоолны 50,804.1 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 7,453.9 мянган төгрөгийн орлого орсон байна.

Он дамжсан төсөл, хөтөлбөрийн үлдэгдэл тооцоо 5,988.9 төгрөгийг сургалтын үйл ажиллагаанд, Эрдэм хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан тэмцээн, уралдааны зардалд 1,465.0 мянган төгрөг зарцуулсан байна.

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 143, сар бүр оруулах мэдээллийн төсвийн хэтрэлт, хэмнэлтийн 836,386.1 мянган төгрөг, тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 84,397.7 мянган төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 гүйлгээний 16,024.6 мянган төгрөг нийтдээ 6 мэдээллийн 936,808.4 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроон байршуулсан байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 211,342.0 мянган төгрөгийн зөрчилд 109,198.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 102,143.6 мянган төгрөгийн зөвлөмжийг 100 хувьтай биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	109,198.4	3	109,198.4	0.0	0.0	100.0
Зөвлөмж	2	102,143.6	2	102,143.6	0.0	0.0	100.0
Нийт дүн	5	211,342.0	5	211,342.0	0.0	0.0	100.0

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 350,849.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 349,165.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,683.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайлан тусгаж, баталгаажууллаа. Үүнд:

Урсгал санхүүжилтийн орлогоор бүртгэсэн 229,514.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр залруулан бүртгэсэн.

Оны эхний үлдэгдэл өр 5,988.9 мянган төгрөгийг төлөхдөө зардалд тусгаагүй шууд өр төлбөрийн дансанд хийсэн бичилтийг зардлаар бичиж залруулсан.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн 113,662.8 мянган төгрөгийн барилга байгууламжийг үндсэн хөрөнгө худалдсаны гарз дансанд бичсэнийг үнэ төлбөргүй гарсан зардал дансанд бичиж залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулаагүй 938,491.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 936,808.4 мянган төгрөг, төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1,683.2 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Гэрэл цахилгааны зардлаас, нүүрсний үнэ 1,305.7 мянган төгрөг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулах;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.Шатахууны зардлаас ажлын хөлс 377.5 мянган төгрөг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ДОА-2021/12/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гэрэл цахилгааны зардлаас, нүүрсний үнэ 1,305.7 мянган төгрөг шилжүүлсэн	1,305.7	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Энхбарс Н.Тунгалаг
2	Шатахууны зардлаас ажлын хөлс 377.5 мянган төгрөг шилжүүлсэн.	377.5	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Энхбарс Н.Тунгалаг
3	Сар бүр оруулах мэдээллийн төсвийн хэтрэлт, хэмнэлтийн 836,386.1 мянган төгрөг, тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 84,397.7 мянган төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 гүйлгээний 16,024.6 мянган төгрөг нийтдээ 6 мэдээллийн 936,808.4 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроон байршуулсан.		Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Энхбарс Н.Тунгалаг
ДҮН		1,683.2			